Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 02/254 дүгээр албан бичгийн нэгдүгээр хавсралт

## НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

## НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 01 — Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Зарцуулсан Төсөв (мян.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2024 | Зорилтот түвшин 2025 | Хүрсэн түвшин (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 1.<br>Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангана. СТ-1.1-1.4, НСТ-2.2, 2.3 | | | | | | | |
| Стратеги төлөвлөгөөний зорилт 1.<br>Иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.<br>НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3, НЗДҮАХ-2.1.7, 2.1.8. | | | | | | | |
| 1.1. | Нийслэл, дүүргийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, биеийн тамир, спортын клуб, өсвөрийн шигшээ багийн багш, дасгалжуулагч, арга зүйч, албан хаагчдад зориулсан сургалтыг зохион байгуулна. | Улсын төсөв 10,040.0 | Зохион байгуулсан сургалтын тоо | 6 | 8 | Нийслэл, дүүргийн хэмжээнд спортын төрлүүдийг хөгжүүлж, багш, дасгалжуулагчдын ур чадварыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох зорилгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, арга зүйч, Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш болон биеийн тамир, спортын клубийн арга зүйч, шүүгчид, сайн дурын ажилтнуудад зориулсан 2025 оны жилийн эцсийн байдлаар 8 төрлийн сургалт зохион байгуулж 225 байгууллагын 1430 багш, дасгалжуулагч, арга зүйчид, оюутнууд оролцсон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2. | Ахмад насны иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд хамруулж дэмжлэг үзүүлнэ. | - | Хамрагдсан иргэдийн тоо | 7042 | 7394 | Нийслэл, дүүргийн хэмжээнд 55-аас дээш насны ахмад иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор 2025 онд нийслэл, дүүргийн хэмжээнд 26 спорт зааланд үнэ төлбөргүй тусгай цаг гарган 56 хорооны 12540 ахмадыг хичээллүүлж байгаа бол 44 арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулж 1234 байгууллагын 9117 ахмадыг хамруулсан.<br>Үүнээс “Улаанбаатар марафон-2025” олон улсын гүйлтийн 1,5км, 5км, 10км, 21км, 42км-ийн зайд 221 байгууллагын 740 ахмадыг хамруулсан байна. | 100% |
| 1.3. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийслэл, дүүргийн хэмжээнд биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулж дэмжлэг үзүүлнэ. | Нийслэл, Улсын төсөв 6,660.0 | Оролцогчдын тоо | 2400 | 2520 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр спорт заал, зориулалтын талбайг нээлттэй, үнэгүй ашиглуулах, секц дугуйлан хичээллүүлэх чиглэлээр 2025 онд Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул дүүргийн биеийн тамир, спортын хороод ашиглалтыг нь хариуцаж байгаа 7 спорт цогцолбор болон 9 дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа 42 спорт заал, 3 усан бассейнд үнэ төлбөргүйгээр 7 хоног бүр хуваарьт цаг гарган шатар, даам, хонхтой бөмбөг, бочи, хэрэглэлтэй сэлэм, фитнес, суугаа волейбол, ширээний теннис, туялзуур сэлэм, тусгай олимпын төрөл, пара бадминтон, корнохол, дип спортын төрлүүдээр секц, дугуйланг хичээллүүлж нийт 106 байгууллагын 2611 иргэнд тогтмол үйлчилгээ үзүүлэн ажилласан.<br>Нийслэлийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг биеийн тамир, спортын тэмцээн, уралдаанд тэгш хамруулах чиглэлээр дүүргийн биеийн тамир, спортын хороодод үүрэг чиглэл өгч ажилласны үр дүнд нийслэл, дүүргийн хэмжээнд нийт 76 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арга хэмжээнд 741 байгууллагын 2611 иргэн хамрагдаж нийт 45.618.709 төгрөгийг зарцуулсан. | |
| Стратеги төлөвлөгөөний зорилт 2.<br>Биеийн тамир, спортын байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх, хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох. НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3, НЗДҮАХ-2.1.7. | | | | | | | |
| 2.1. | Төрийн болон аж ахуй нэгж байгууллагын Биеийн тамир, спортын клубын тоог нэмэгдүүлж үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | - | Клубын тоо | 815 | 820 | Нийслэлийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар БЗД-ийн 29-р хороо, БЗД-ийн 30-р хороо, БЗД-ийн 31-р хороо, БЗД-ийн 32-р хороо шинээр 4 клуб байгуулж нийт 820 биеийн тамир, спортын хамтлаг үйл ажиллагаагаа тогтмолжуулан ажиллаж байна. Биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нийтэд таниулах, урамшуулах зорилгоор Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын клубийн шалгаруулах болзлын дагуу Олон улсын худалдаа логистикийн төв ХК, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын клубүүдийг "Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын клуб"-аар шалгаруулан өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. | 100% |
| 2.2. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг авах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж нэгдсэн мэдээллийн санд оруулна. | Нийслэлийн төсөв | Нийслэлийн хэмжээнд сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт | 74% (А, В, С үнэлгээ авсан байна) | 75% (А, В, С үнэлгээ авсан байна) | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг Нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулж 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 606 байгууллагын 85,122 иргэн хамрагдсан байна.<br>Сорилд хамрагдсан хүмүүсийн: 26 % нь- А, 28 % нь- В, 23 % нь- С, 15 % нь- D, 8 % нь- F үнэлгээ авсан ба нийт 77% нь А,В,С үнэлгээ байна. Сорилд хамрагдсан иргэдийн мэдээлэл, чанарын үзүүлэлтийг cpanel.sport.gov.mn сайтад шивж оруулсан. | 100% |
| Стратеги төлөвлөгөөний зорилт 3.<br>Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх НХТЖҮЧ-3.5.4, НЗДҮАХ-2.1.8, НХТ-161, 162. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1. | Оюутны шигшээ багийг спортын 8 төрлөөр байгуулах журмыг боловсруулж шаардагдах төсвийг 2026 оны төсөвт тусгуулна. /Биеийн тамир, спортын тухай хуулийн 23.6/ | - | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Нийслэлийн Засаг даргын дэргэдэх оюутны шигшээ багийг спортын 8 төрлөөр байгуулах журмыг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1626 дугаар захирамжаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Оюутны шигшээ багт шаардагдах төсвийг Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгаж, нийслэлийн 2026 оны төсөвт 1,165.000.0(нэг тэр бум нэг зуун жаран таван сая) төгрөгийг батлуулахаар саналыг хүргүүлэн ажилласан. | 100% |
| 3.2. | "Даншиг наадам-Хүрээ цам" наадмын үндэсний бөхийн барилдаан, үндэсний сур харвааг зохион байгуулна. | Нийслэлийн төсөв | Оролцогчдын тоо | 436 | 436 | Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр Хүрээ цам-Даншиг наадам-2025" шашин соёлын наадмын үндэсний бөх, Үндэсний сурын харвааг 2025 оны 06 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Хүй долоон худагт зохион байгуулж нийт 1256 бөх харваачид оролцсон. Тус арга хэмжээг зохион байгуулахад Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/833 дугаар захирамаар 263,054,000 төгрөг зарцуулсан. | 100% |
| 3.3. | Гадаад, дотоодын биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцуулах, харилцан туршлага судлах ажлыг зохион байгуулна. | Улсын төсөв 8,400.0 | Арга хэмжээний тоо | 10 | 12 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 онд гадаад, дотоодын биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцуулах, харилцан туршлага судлах 12 ажил төлөвлөж бүрэн гүйцэтгэж 196 хүн хамрагдсан. Дүүргийн Засаг дарга нарын дэргэд өсвөрийн шигшээ багийг давхардсан тоогоор спортын 28 төрөлд 95 багт 95 дасгалжуулагчтай 4001 тамирчдыг бэлтгэл сургуулилтад хамруулснаар 2025 оны жилийн эцсийн байдлаар тив, дэлхийн 19, олон улсын 37 тэмцээнд оролцож 309 медаль хүртсэн амжилт үзүүлсэн байна. Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж Улс, нийслэл, ивээн тэтгэгчдээс нийт 573,254,500 төгрөгийг зарцуулсан байна. | 100% |
| Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж болон спортын барилга байгууламжийн хүртээмжийг тус тус нэмэгдүүлнэ. НХТЖҮЧ-3.5, НЗДҮАХ-2.1,7. НХТ-153, 154, 155 | | | | | | | |
| Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт: 1.<br>Нийслэлийн иргэдийг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөө-нөөр тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлж, бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын түвшний суурь үзүүлэлтийг 5 хувиар өсгөнө. НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3, НЗДҮАХ-2.1.7, НХТ-153, 154, 155, 156 | | | | | | | |
| 1.1. | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллана. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 99 | 25 | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, байгууллагын даргын 2025 оны А/23 дугаар тушаалаар батлаж, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллалаа. 2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. | 100% |
| 1.2. | Биеийн тамир, спортын хуулийн дагуу дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулахад холбогдох баримт бичгийг боловсруулж 2026 оны төсөвт тусгуулна. | - | Хэрэгжилтийн хувь | - | 100 | Дүүргийн хороодод орон тооны арга зүйч ажиллуулах тухай саналыг холбогдох дээд байгууллагуудад хүргүүлж, "Биеийн тамир, спортын тухай хууль"-д заалт болгож тусгуулсан.<br>Нийслэлийн хэмжээнд хэрэгжилтийг хангаж 2025 оны жилийн эцсийн байдлаар орон тооны арга зүйч ажиллуулахад шаардлагатай орон тоо, цалин хөлс, сургалтын төсвийн тооцооллыг боловсруулж 2026 оны төсөвт тусгуулахаар ЗГТА-Биеийн тамир, спортын улсын хороонд саналыг хүргүүлж, ажилласан. | 100% |
| 1.3. | Нийтийг хамарсан биеийн тамирын томоохон (Улаанбаатар марафон, Иргэдийн спортын "Хангарди" наадам, Бүжгийн фестиваль, Нийтийн гимнастикийн фестиваль, "Улаанбаатар цом" усанд сэлэлтийн фестиваль, "Алхацгаая-гүйцгээе" | Нийслэлийн төсөв Улсын төсөв 34,460.0 | Хамрагдсан иргэдийн тоо | 888,500 | 916,978 | Нийслэлийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийтийг хамарсан 270 (сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сургалт, хөгжөөн дэмжигчдийн арга хэмжээ, уран хөдөлгөөнт гимнастик, софт, хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил, "Улаанбаатар марафон-2025", "Алхацгаая гүйцгээе" хөдөлгөөн, олон улсын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлгөөн гэх мэт) арга хэмжээнүүдийг зохион байгуулна. | | | | | хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ) гэх мэт арга хэмжээ зохион байгуулж 6600 байгууллагын 1,117,358 иргэдийг хамруулсан. | |
| 1.4. | Нийслэлийн өвлийн спортын 9 арга хэмжээ, 5 төрөл (Цанын бааз, мөсөн гулгуурын талбай, битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбай, өдөрлөг, секц дугуйлан)-ийн үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллана. | Нийслэлийн төсөв | Зохион байгуулсан ажил | 12 | 14 | Өвлийн улиралд иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр 20 удаагийн биеийн тамир, спортын арга хэмжээ, 27 байршилд мөсөн гулгуурын талбай, цанын баазыг байгуулж, биеийн тамир, спортын үйлчилгээг нийт 447,595 иргэдэд хүргэж ажилласан. Үүнд:<br>-Нийслэлийн 9 дүүрэгт нийтийг хамарсан 11 арга хэмжээ зохион байгуулж 26,709 иргэнийг хамруулсан.<br>-Өвлийн спортын төрлөөр Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаан, тэмцээнийг 7 удаа зохион байгуулж 693 тамирчин оролцсон.<br>-Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багт өвлийн спортын 3 төрөл (хоккей, тэшүүр, шорттрейк)-ийн төрлөөр 95 хүүхэд, багачууд секц, дугуйланд хамрагдаж байна.<br>-Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт байрлах битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбайд 2025 оны 01 дүгээр сарын 02-ноос 11 дүгээр сарын 27-ны хооронд 132,098 иргэн үйлчлүүлсэн байна.<br>-Сүхбаатар, Баянзүрх, Багануур дүүрэгт Хандгайт, Скай ресорт, Галуут тур, Улаанбаатар цанын баазуудад 172,000 иргэн үйлчлүүлсэн байна.<br>-Орон сууц, гэр хорооллын 22 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдаж 116,000 иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна. | 100% |
| | | | Хамрагдсан иргэдийн тоо | 425,000 | 446,335 | | |

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 2.
Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлж, нийслэлийн иргэдийн дунд зохион байгуулах уралдаан, тэмцээн наадмын төрлийг нэмж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэж суурь үзүүлэлтийг 5 хувиар ахиулна. НХТЖҮЧ-3.5.4, 3.5.5, НЗДҮАХ-2.1.8., НХТ-160, 161, 162, 156.

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1. | Багийн спортыг дэмжих чиглэлээр өсвөрийн хүүхэд багачуудын дунд “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейболын тэмцээн, “Мөрөөдлийн гоол” хөл бөмбөгийн фестивалийг зохион байгуулна. | Нийслэлийн төсөв | Оролцогчдын тоо | 158,746 | 166,683 | Багийн спортын төрлөөр дамжуулан өсвөр үеийн хүүхэд, багачуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, хамтач үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор 2025 оны жилийн эцсийн байдлаар “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейболын тэмцээн, Мөрөөдлийн гоол” хөл бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж 8728 багийн 166,694 хүүхэд, залуучуудыг оролцуулж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/323 дугаар захирамжаар 301,178,000 төгрөгийг зарцуулсан байна. | 100% |
| 2.2. | Спортын холбоодтой 2025 онд хамтран ажиллах гэрээ байгуулан Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 21 төрлөөр зохион байгуулна. | Улсын төсөв 61,440.0 | Тамирчдын тоо | 7,888 | 8,282 | Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих, спортын төрлийг хөгжүүлэх зорилгоор 2025 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг 21 төрлөөр спортын холбоодтой хамтран зохион байгуулж 443 байгууллагын 8631 тамирчдыг хамруулсан. | 100% |
| 2.3. | Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг байнгын дасгал сургалт хийх нөхцөлийг хангаж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэнэ. | - | Тамирчдын тоо | 3,150 | 3,307 | Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх, дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж спортын 28 төрөлд 95 багт 95 дасгалжуулагчтай 4001 тамирчдыг бэлтгэл сургуулилтад хамруулж байна.<br>Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2025 оны жилийн эцсийн байдлаар 382 удаагийн тив, дэлхий, олон улс, улс, нийслэл, нэрэмжит тэмцээнд оролцож 2067 медаль авсан амжилт үзүүлсэн байна. Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж Улс, нийслэл, ивээн тэтгэгчдээс нийт 573,254,500 төгрөгийг зарцуулсан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4. | Бүх ард спортын XVII наадам, Хүүхдийн спортын VIII наадмын анхан шатны тэмцээнүүдийг зохион байгуулна. | Нийслэлийн төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 | Монгол Улсын Засгийн газрын 183 дугаар тогтоолын дагуу Монголын хүүхдийн спортын өвөл, зуны VIII наадмыг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл зохион байгуулж, нийт 40 спортын төрлөөр 6666 тамирчид оролцсон.<br>Монголын хүүхдийн спортын өвлийн наадамд 1-р байранд Баянзүрх дүүрэг, Зуны спортын наадамд: 1-р байранд Хан-Уул дүүрэг, 2-р байранд Сүхбаатар дүүрэг, 3-р байранд Чингэлтэй дүүргийн баг тамирчид тус тус эзэлсэн байна. | 100% |
| Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 3.<br>Нийслэлийн иргэдийн 15 хувь нь оршин суух газраасаа 20 минут алхаж хүрэх зайд ногоон байгууламж бүхий спортын цогцолборыг бий болгох, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцлийг сайжруулж, спортын барилга, байгууламжийн хүртээмжийг 1000 хүнд 70 м2-д хүргэж нэмэгдүүлнэ. НХТЖҮЧ-3.5.2, НЗДҮАХ-2.1.9, НХТ-157, 158, 159 | | | | | | | |
| 3.1. | Сонгинохайрхан дүүргийн өвлийн спортын ордон, Баянзүрх, Багахангай дүүргийн спорт цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлнэ. | Улсын төсөв 5,526,400.0 | Гүйцэтгэлийн хувь | 55 | 70 | Улсын төсвөөр баригдаж байгаа Багахангай, Баянзүрх дүүргийн спорт цогцолбор, Сонгинохайрхан дүүргийн өвлийн спортын ордон, усан спортын төвийн барилгын явцын биелэлтийг холбогдох байгууллагуудаас цаг тухай бүр авч бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан заалт тус бүрээр биелэлтийг гаргаж байгууллагын удирдлага болон дээд шатны байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна.<br>Үүнд: Сонгинохайрхан дүүргийн 34-р хороонд баригдаж байгаа усан спортын төвийн барилга баригдаж дууссан бөгөөд улсын комисст өгөх ажил хүлээгдэж байна. Баянзүрх дүүргийн спорт цогцолбор 85 хувьтай, Багахангай дүүргийн спорт цогцолбор 95 хувьтай, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд баригдаж байгаа өвлийн ордон 50 хувьтай, Хан-Уул дүүргийн Оюуны спортын ордон 90 хувьтай баригдаж байгаа бөгөөд нийт ажлуудын гүйцэтгэл 84.4 хувьтай хэрэгжиж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2. | Баянхошуу дэд төвийн спортын цогцолборын барилгын ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ашиглалтад оруулна. | Азийн хөгжлийн сан 3,000,000.0 Нийслэлийн төсөв | Гүйцэтгэлийн хувь | 70 | 100 | Азийн хөгжлийн банкны 60 хувь, нийслэлийн төсвийн 40 хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Сонгинохайрхан дүүргийн Баянхошуу дэд төвийн спорт цогцолбор 85 хувьтай үргэлжилж байна. 2025 онд дотор засал болон гадна тохижилтын ажил хийгдэж байна. Мөн усан бассейны түргэн тусламж үзүүлэх эмнэлгийн багаж, төхөөрөмж, фитнесийн тоног, төхөөрөмжийн худалдан авалт хийгдээд байна. | 90% |
| 3.3. | Биеийн тамир, спортын талбайн бүтээн байгуулалт, тохижилтыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | - | Бүтээн байгуулсан тохижуулсан талбайн тоо (өссөн дүнгээр) | 203 | 223 | 2025 онд Сонгинохайрхан дүүргийн 3-р хороонд хөл бөмбөгийн хиймэл зүлэг бүхий спортын иж бүрэн талбай шинээр байгуулагдсан бол бусад дүүргүүдэд 20 байршилд спортын зориулалтын талбайг хувийн аж ахуй нэгж байгууллагуудаас шинэчлэн тохижуулж нийт 234 талбай болсон. Үр дүн: Биеийн тамир, спортын зориулалтын талбай 2019 оны суурь үзүүлэлт 101 байсан бол 2025 оны байдлаар 133-аар нэмэгдэж 234 болсон. | 100% |
| 3.4. | Нийслэлд спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | - | Спортын барилга байгууламжийн хүртээмж (м2) | 65 | 66 | Нийслэлийн хэмжээнд 1000 хүнд ногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 2021 онд 61м$^2$, 2022 онд 62м$^2$, 2023 онд 63,5м$^2$, 2024 онд 65 м$^2$-д хүрсэн үр дүнтэй байна. Үүнд: 2021 онд 5 спортын заалтай барилга, 2022 онд 4 спортын заалтай барилга, 2023 онд 7 спортын заалтай барилга, 2024 онд 8 спортын заалтай барилга, нийт 19 спортын заалтай барилга ашиглалтад орсон.<br>2025 онд улсын төсвөөр Сонгинохайрхан дүүргийн 34-дүгээр хороонд усан спортын төв 100 хувьтай, Баянзүрх дүүргийн спорт цогцолбор 85 хувьтай, Нийслэлийн Спорт цогцолбор 40 хувьтай, Багахангай дүүргийн спорт цогцолбор 95 хувьтай, Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны өвлийн ордон 50 хувьтай, Хан-Уул дүүргийн оюуны спортын ордон 90 хувьтай баригдаж байгаа бол | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сүхбаатар дүүргийн төсвөөр баригдаж байгаа спорт цогцолборын хэрэгжилт 80 хувьтай, Азийн хөгжлийн банкны 60 хувь, нийслэлийн төсвийн 40 хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Баянхошуу дэд төвийн спорт цогцолбор 85 хувьтай үргэлжилж байгаа бөгөөд 2026 оны эхний улиралд 2025 оны 1000 хүнд ногдох спортын барилга байгууламжийн хүртээмжийн статистик тоо гарна. | |
| Зорилт 4.<br>Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт | | | | | | | |
| 4.1. | Улс, нийслэл, байгууллагын дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бусад холбогдох баримт бичгүүдэд санал боловсруулан хүргүүлж ажиллана. | - | Санал өгсөн баримт бичгүүдийн тоо | 12 | 12 | 2025 онд бодлогын баримт бичиг нийт 12 удаа санал боловсруулан албан тоотоор холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллаа.<br>Үүнд: Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө зэрэг томоохон бодлогын баримт бичгүүдэд байгууллагын чиг үүргийн дагуу тусгах ажлын саналыг боловсруулан тайлбар, танилцуулгын хамт холбогдох байгууллагуудад хүргүүлж тусгуулж ажилсан. | 100% |
| 4.2. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээг нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлнэ. | - | Хугацаа хоцроосон тайлан мэдээний тоо | Хугацаа хэтэрч явуулсан тайлан мэдээний тоо 0 | Хугацаа хэтэрч явуулсан тайлан мэдээний тоо 0 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2025 оны жилийн эцэст 19 тайлан, мэдээг гаргахаар төлөвлөснөөс хугацаандаа тайлагнасан 18, хугацаа нь болоогүй 1 тайланд боловсруулалт хийж хугацаанд нь хүргүүлэхээр ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлтсүүд, дотоод удирдлагын нэгдсэн программ ERP-н Хяналт шинжилгээ, үнэлгээ дэд системд оруулж ажилласан бөгөөд хугацаа хэтэрч явуулсан тайлан, мэдээ гараагүй байна. | |
| 4.3. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн төлөвлөгөөнд манай байгууллагад хариуцуулан тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | - | Хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн тайлангийн тоо | 10 | 10 | Бодлогын баримт бичигт хяналт шинжилгээ хийх 12 ажил бүхий төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагааны 12 /давхардсан тоогоор/ тайлан, мэдээнд хяналт-шинжилгээ хийхээр төлөвлөн явцын хяналт-шинжилгээг 10 тайланд хийсэн бөгөөд боловсруулалт хийгдэж байгаа 2 тайлан байна. | 100% |
| 4.4. | Байгууллагын албан хаагчдын шилжилт хөдөлгөөний мэдээг төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын системд оруулна. | - | Шинэчилсэн мэдээллийн тоо | 14 | 15 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84, 238 дугаар тогтоолоор албан хаагчдын цалин хөлс, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах өөрчлөлтүүдийг 2 удаа давхардсан тоогоор 24 албан хаагчийн мэдээллийг төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын систем”-д шинэчилж оруулсан. Мөн байгууллагын 16 албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын систем”-д оруулж баталгаажуулсан байна. | 100% |
| 4.5. | Биеийн тамир, спортын салбарын байгууллагуудын статистик судалгааны дүн мэдээг шинэчилж нэгтгэн цахим программд оруулна. | - | Цахим програмд оруулсан мэдээний тоо | 7 | 7 | Биеийн тамир, спортын төрийн байгууллагын үйл ажиллагааны 2024 оны 7 төрлийн мэдээг Үндэсний Статистикийн газрын 3-БТС-1, А-БТС-6, А-БТС-7 маягтын дагуу бэлтгэн https://cpanel.sport.gov.mn/ программд оруулж pdf хэлбэрээр 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын Улсын хорооны www.info@sport.gov.mn хаягаар хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.6. | Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг тайлагнах, ХАСХОМ гаргах албан хаагчдыг хуулийн хугацаанд мэдүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт 24 арга хэмжээг зохион байгуулахаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийн эхний хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 02/158 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.<br>Жилийн эцсийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр буюу хугацаанд нь дээд газарт хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. ХАСХОМ-ийг мэдүүлэх нийслэл, дүүргийн биеийн тамир спортын газар, хороодын 51 албан хаагчид хуулийн хугацаанд мэдүүлгийг гарган баталгаажуулж, мэдээллийг Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлж ажилласан.<br>Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ХАСХОМ гаргах албан хаагчдад зориулан зохион байгуулсан 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 69 албан хаагчийг хамруулан ажилласан. 2025 онд авлига ашиг сонирхлын зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно. | 100% |
| 4.7. | Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог шинэчлэн батлаж ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллана. | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Нийслэлийн биеийн тамир, спортын газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/28 тушаалаар Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын Ёс зүйн дэд хороог 3-н хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ёс зүйн дүрмийг шинэчлэн батлуулсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй бөгөөд иргэд, аж, ахуйн нэгж байгууллагаас албан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй байна. | |
| 4.8. | Нийслэлийн 2025 оны төсөвт батлагдсан байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр, авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнана. | Нийслэлийн төсөв 8,838.7 | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын байр ашиглалтын зардалд 2025 онд 8,838,700(найман сая найман зуун гучин долоон мянган) төгрөг батлагдсан бөгөөд 2025 оны жилийн эцэст 8,838,700( найман сая найман зуун гучин долоон мянган) төгрөгийн санхүүжилт авч 5,472,000 (таван сая дөрвөн зуун далан хоёр мянган) төгрөгийг зарцуулан, өр авлага үүсгэлгүй ажиллаж сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь хүргүүлж ажилласан. | 100% |
| 4.9. | Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна. | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 2025 оны жилийн эцсийн байдлаар биеийн тамир, спортын чиглэлээр гарсан шүүхийн маргаан байхгүй байна. | 100% |
| 4.10. | Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомж болон бусад хууль, тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлнэ | - | Хүргүүлсэн саналын тоо | 1 | 1 | Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгад Оюутны шигшээ багийг Нийслэлийн Засаг даргын дэргэд байгуулахаар санал боловсруулан хуульд тусгаж, хэрэгжилтийг ханган Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1626 дугаар захирамжаар оюутны шигшээ багийг спортын 8 төрлөөр байгуулах журмыг батлуулсан.<br>Оюутны шигшээ багт шаардагдах төсвийг Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгаж, нийслэлийн 2026 оны төсөвт 1,165.000.0(нэг тэр бум нэг зуун жаран таван сая) төгрөгийг батлуулахаар саналыг хүргүүлэн ажилласан. | 100% |
| 4.11. | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс | - | Хэрэгжүүлсэн ажлын тоо | 11 | 12 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 онд зохион байгуулсан томоохон 13 арга хэмжээнд оролцсон багш, арга зүйч, оролцогчидод гэмт хэрэг, зөрчлөөс | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. | | | | | урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 9.9 дэх заалт, Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хэм хэмжээг танилцуулж, мэдээллээр хангаж ажилласан. Үүнд: (Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Улаанбаатар лиг" сагсан бөмбөгийн техникийн зөвлөгөөн, Цэцэрлэгийн хүүхдүүдийн Уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнүүдийн техникийн зөвлөгөөн, Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш, арга зүйчдийг чадавхжуулах сургалт, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын биеийн тамирын багш, арга зүйчдэд зориулсан чадавхжуулах сургалт, Хөгжөөн дэмжигчдийн сургалт, "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтийн техникийн зөвлөгөөн) гэх мэт. | |
| 4.12. | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана. | - | Хэрэгжүүлсэн ажлын тоо | 11 | 11 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 6 үйл ажиллагаа хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг 100 хувийн гүйцэтгэлтэй хангаж ажиллаж тайланг хүргүүлж ажилласан. "Харилцан хүндэтгэе" нэг сарын аян, "Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-д нэгдэж 11 ажил зохион байгуулсан. | 100% |
| 4.13. | Биеийн тамир, спортын чиглэлээр шинээр боловсруулах, шинэчлэх шаардлагатай стандарт, нормд санал өгөх, сурталчилан хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | - | Сурталчилж ажилласан ажлын тоо, хүртээмж | 4 ажил, 1230 хүн | 5 ажил, 1250 хүн | Биеийн тамир, спортын салбарын хэмжээнд мөрдөгдөж буй 19 стандарт болон хотын хэмжээнд батлагдсан 52 стандартыг 5 удаагийн сургалтын хөтөлбөрт тусган зохион байгуулж 130 байгууллагын 1310 хүнийг мэдээллээр хангаж ажиллаа. Үүнд: Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 оны 01 дүгээр сарын 30-аас 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан сургуулийн ерөнхий боловсролын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн биеийн тамирын багш нарын сургалтад 9 дүүргийн 80 ерөнхий боловсролын 130 биеийн тамирын багш нар хамрагдсан бол "Улаанбаатар марафон 2025" олон улсын гүйлтийн шүүгч, сайн дурын ажилтанд чиглэл өгөх 2 удаагийн сургалтад 40 байгууллагын 550 ажилтан хамрагдсан. Мөн Сурагчдын лиг сагсан бөмбөг, волейболын техникийн зөвлөгөөнд оролцсон 630 багш, дасгалжуулагч нарыг мэдээллээр хангаж ажиллаа. | |
| Зорилт 5.<br>Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: | | | | | | | |
| 5.1. | Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмыг шаардлагын дагуу хангаж ажиллана. | - | Хэрэгжүүлсэн чиг үүргийн тоо | 6 | 8 | Байгууллагын архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 онд 2 зорилт, 8 арга хэмжээ зохион байгуулахаар батлуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнан ажилласан. Үүнд: 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын архивд байнга, түр, 70 жил хадгалах нийт 98 хадгаламжийн нэгжийг хүлээн авч архивын баяжилт хийсэн.<br>Байгууллагад 2024 онд үүсэж хөтлөгдсөн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан 52, хүний нөөцийн чиглэлээр гаргасан 26 тушаалыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн программ (arch.ulaanbaatar.mn) системд захирамжлалын баримтаа цахим хэлбэрт шилжүүлж, Нийслэлийн Архивын газарт актаар хүлээлцсэн.<br>Нийслэлийн Архивын газрын төрийн архивд баримт шилжүүлэх хуваарийн дагуу байгууллагын 2015-2022 оны архивын баримтыг данс, бүртгэл, устгах баримтын жагсаалтыг үйлдэн Нийслэлийн Архивын газрын дэргэдэх баримт шалгах арга зүйн комиссоор хэлэлцүүлэн батлуулж, 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байнгын 198, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захирамжлалын 16, дүрс бичлэг 21 хадгаламжийн нэгжийг төрийн архивд хүлээлгэн өгсөн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Улсын үзлэгт бэлтгэх тухай” 23 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын “Улсын үзлэг зохион байгуулах тухай” А/1220 дугаар захирамж, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2025 оны “Архив, албан хэрэг хөтлөлт, ажлыг зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулах тухай” А/31 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангаж улсын үзлэгт бэлтгэх 4 хэсгийн 44 зүйл, заалттай төлөвлөгөөг батлуулан бэлтгэл ажлыг хангаж 2025 оны 11 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд улсын үзлэгийн ажлын хэсэгт үйл ажиллагаагаа шалгуулж байгууллагын архивын төлөвлөгөөний 6 зорилт, 8 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллалаа. | |
| 5.2. | Байгууллагын хэмжээнд дотоод хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Дотоод хяналт шалгалт хийсэн ажлын тоо | 4 | 2 | Байгууллагын хэмжээнд дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг 9 үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж 2025 оны жилийн эцсийн байдлаар дотоод хяналт шалгалтыг байгууллагын ил тод байдал, шилэн данс, байгууллагын бүтэц, орон тоо, чиг үүрэгт хийж ЗГХА-Биеийн тамир, спортын улсын хороонд хүргүүлж ажилласан. | 100% |
| 5.3. | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын байнгын үйл ажиллагаатай хороо, комисс, зөвлөлүүд тус бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Өмч хамгаалах байнгын зөвлөлийг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр байгууллагын даргын А/12 тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар шинэчлэн батлуулсан. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл нь байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийг хагас, бүтэн жилээр хийхээр төлөвлөсөн бөгөөд зөвлөлийн үйл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллаж байна.<br>Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Ёс зүйн дэд хороог 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хамт олны хурлаар хэлэлцэн санал хурааж 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, байгууллагын даргын 2025 оны А/13 тушаалаар батлуулж, 2025 оны Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан хагас, бүтэн жилээр хэрэгжилтийг тайлагнахаар төлөвлөн, хагас бүтэн жилийн тайланг холбогдох дээд байгууллагуудад хүргүүлсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй бөгөөд иргэд, аж, ахуйн нэгж байгууллагаас албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй байна.<br>Байгууллагын даргын 2025 оны А/27 дугаар тушаалаар “Баримт нягтлан шалгах комисс”-ыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, дүрэм, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2 зорилт 6 арга хэмжээтэй батлуулж, хагас, бүтэн жилээр хэрэгжилтийг тайлагнан ажиллалаа. | |
| 5.4. | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих ажлыг зохион байгуулна. | - | Тарьсан модны тоо | 10 | 20 | Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны хавар, намрын мод тарих арга хэмжээнд нэгдэж Баянгол цэцэрлэгт хүрээлэнд урд жилүүдэд тарьсан 40 хайлаас модыг арчлах, услах ажлыг зохион байгуулж, нэмж 20 хайлаас модыг 12 албан хаагч тарьсан бөгөөд арчилгааг Баянгол цэцэрлэгт хүрээлэнд хариуцуулж өгсөн. | 100% |
| Зорилт 6.<br>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт: | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн программ /erp.ulaanbaatar.mn/-ын дэд системүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандаа үргэлжлүүлэн ашиглана. | - | Ашигласан дэд системийн тоо | 14 | 15 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийн /erp.ulaanbaatar.mn/-ын 16 (хүний нөөцийн удирдлага; шийдвэр; хурлын заал захиалгын систем; тогтоол шийдвэр; хяналт шинжилгээ үнэлгээ; утасны жагсаалт; цаг бүртгэл; ажлын хэсэг, хурал, уулзалт, үүрэг даалгавар; судалгаа; тайлан судалгаа; өргөдөл гомдол; төрийн үйлчилгээ; онлайн бизнес төв; унааны захиалгын систем; Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төв; edoc)-н дэд системийг өдөр бүр болон тухай бүр үйл ажиллагаандаа үргэлжлүүлэн ашиглаж байна. | 100% |
| 6.2. | Иргэдийг хүлээж авах хуваарь гарган, санал хүсэлтийг цаг тухайд нь шийдвэрлэж ажиллана. | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхээр Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын удирдлагууд иргэдийг цайны цагаас бусад бүх цагт хүлээн авч уулзаж, асуудлыг нь тухай бүр шийдвэрлэхээр хуваарь гарган ажиллаж 2025 оны жилийн эцсийн байдлаар 15 иргэнийг хүлээн авч 10 хүсэлтийг шийдвэрлэсэн. | 100% |
| 6.3. | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Шийдвэрлэлтийн дундаж хугацаа | 4 хоног 20 цаг | 4 хоног | Биеийн тамир, спортын чиглэлээр иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг 17 эх үүсвэрээр хүлээн авах зохицуулалтын дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар 32 өргөдөл, гомдол ирснийг шалтгаан нөхцөлийг тодорхойлж, холбогдох ажилтанд шилжүүлж, тухай бүр удирдлагад танилцуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, иргэний талд шийдвэрлэсэн 23, боломжгүй хариу өгсөн 9, шийдвэрлэлтийн дундаж 2 хоног 12 цаг 49 минут байна. | 100% |
| 6.4. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем | - | Албан бичгийн шийдвэрлэлтийн хувь | 98 | 99 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн программ (edoc.ulaanbaatar.mn) систем буюу цахим хаягаар 2025 оны 12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэх edoc.ulaanbaatar.mn системийн ашиглалтыг сайжруулан албан бичгийн шийдвэрлэлтийг хангаж ажиллана. | | | | | дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 353 албан бичиг ирснээс шийдвэрлэлтийн дундаж хувь 99 байна. Явуулсан 251 албан бичгийг бүртгэж үйл ажиллагааг тогтмолжуулж албан бичгийг хугацаанд нь холбогдох байгууллагад шилжүүлэн шийдвэрлэж байна. | |
| 6.5. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын чиг үүргийн хүрээний мэдээллийг олон нийтэд ил тод хүргэж ажиллана. | - | Байршуулсан мэдээллийн тоо | 68 | 69 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангаж зайлшгүй байрших 5-н чиглэл (1.чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын-18; 2.хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын-7; 3.төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын-29, үүнээс байгууллагад хамааралгүй-12; 4.үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдлын-6; 5.бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын-27, үүнээс байгууллагад хамааралгүй-15)-ийн 87 мэдээ, мэдээллээс байгууллагад хамааралтай 72 мэдээ мэдээллийг sport.ub.gov.mn цахим хуудсанд бүрэн байршуулж, улирал, хагас, бүтэн жилээр shilengov.mn системд оруулан тайланг илгээн ажиллаж байна. | 100% |
| 6.6. | Нийслэлийн тэргүүний биеийн тамир, спортын байгууллага, спортын холбоод, хамтрагч байгууллага, хамтлаг, мэргэжилтэн, багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйчдийн хэрэгжүүлсэн ажилд үнэлэлт дүгнэлт өгч, шалгаруулж урамшуулна | Улсын төсөв 15,500.0 | Болзлын дагуу шалгарсан шилдгүүдийн тоо | 11 | 22 | Нийслэлийн хэмжээнд 2025 онд ажил, амжилтаараа тэргүүлсэн тэргүүний биеийн тамир, спортын байгууллага, спортын холбоод, хамтрагч байгууллага, хамтлаг, багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйч зэрэг 22 номинацийг шалгаруулахаар журмаар батлан дүүргийн Биеийн тамир, спортын хороод болон байгууллагын www.sport.ub.gov.mn сайтад байршуулж материалыг 2025 оны 12 дугаар сарын 05-ны дотор хүлээн авч шагналыг 2025 оны 12 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сарын 23-нд гардуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. | |
| 6.7. | Биеийн тамир, спортын үйлчилгээ, хүртээмжийн талаарх судалгааг судалгааны багтай хамтран зохион байгуулж, үр дүнг тодорхойлно. | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын удирдлага "Монголын спортын сэтгэл судлаачдын холбоо"-ны эрдэм шинжилгээ, судалгааны албаны удирдлагатай уулзалт хийж, нийслэлийн иргэд оршин суух газраасаа "20 минутын зайд" алхаж хүрэх биеийн тамир, спортын үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх, хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, шилжилт хөдөлгөөн, тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдсан судалгааны ажил хийлгэхээр тохиролцсон. Үүний хүрээнд биеийн тамир, спортын салбарын холбогдолтой тоон мэдээллийг хүргүүлэн судалгааны ажлыг эхлүүлсэн. | 90% |
| 6.8. | Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын зарим үйлчилгээг цахимд шилжүүлэх чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулна. | - | Цахимд шилжүүлсэн үйлчилгээний төрлийн тоо | 8 | 9 | Нийслэлийн Засаг даргын 2021 оны "Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/987 дугаар захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журмын 2.5.1-2.5.5 дахь "фитнес, спининг", "усан бассейн", "боулинг", "аэробик, иог, бүжгийн клуб", "бильярд" гэсэн эхний 5 чиглэлийн үйлчилгээг "Онлайн бизнес төв" платформын Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем /http://service.ulaanbaatar.mn/home /-д 2022 оноос эхлэн иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд бүртгүүлж 2025 онд жилийн эцсийн байдлаар 59-н аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс бүртгүүлснээс зөвшөөрсөн-29, баталгаажуулахаар шилжүүлсэн-3, буцаасан-24, татгазлсан-3 хүсэлт байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/262 дугаар тушаалаар байгуулсан "Онлайн биенес төв"-ийн "Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем"-ээр бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлж буй цахим үйлчилгээ, түүнтэй холбоотой систем хөгжүүлэлтийн ажлын даалгаврыг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. Үүний дагуу дээрх нийтлэг журмын 2.5.6, 2.5.7, 2.5.8, 2.5.10, 2.5.11 дэх заалтад тусгагдсан үйлчилгээг нэмэх, биеийн тамир, спортын үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий 2 байгууллагын холбогдох нэгжүүдээс гаргуулсан дүгнэлт, зөвшөөрөл бүхий эрх зүйн актыг байршуулдаг цэсийг оруулах тухай саналыг нэгтгэн НЗДТГ-ын Дэд бүтэц, техникийн хяналтын хэлтэст 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 02/234 дүгээр албан бичгийн хамт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний газрын даргад 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 02/78 дугаар албан бичгийн хамт тус тус хүргүүлсэн. | |
| 6.9. | Байгууллагын чиг үүрэгт хамаарах “Хотын хөгжлийн индекс”-ийн холбогдох үзүүлэлтийн тоон мэдээллийг цуглуулах, нэгтгэх, мэдээлэх тогтолцоог бий болгох, суурь үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Төлөвлөгөөний хэрэгжилт | 0 | 100 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь Хотын хөгжлийн “Спортын хүртээмж” буюу 57-р индексийн үзүүлэлтэд хамрагдаж 2025 онд индексийг сайжруулахад чиглэсэн ажлууд хийгдэж байна.<br>Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төв НТҮГ-аас Улаанбаатар хотын хөгжлийн индексийг шинэчлэн боловсруулж байгаатай холбогдуулан Нийслэйин Биеийн тамир, спортын газрын чиг үүрэгт хамаарах үзүүлэлт, статистик тоон мэдээллийг 2024 оны жилийн эцсийн байдлаар гарган 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 02/231 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.10. | Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, ажилтан албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн ур чадвар, мэдлэгийг сайжруулах төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллана. | - | Төлөвлөгөөний хэрэгжилт | 100 | 100 | Байгууллагын албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөнд Монгол хэл бичгийг албан хэрэг хөтлөлтөд хэрэглэж хэвших талаар 4 арга хэмжээг зохион байгуулахаар тусгаж, байгууллагын 12 албан хаагчдыг 3 удаагийн сургалтад хамруулж, Биеийн тамир, спортын Улсын хороо болон Нийслэлийн Архивын газарт туршлага судлах дадлага ажлыг зохион байгуулсанаар албан хаагчид захирамжлал болон зохион байгуулалтын баримт бичгийг монгол бичгээр боловсруулж үндэсний бичгийг албан хэрэгцээнд 100 хувь ашигладаг болсон. | 90% |
| Дундаж хувь: | | | | | | 98.93% | |

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 2 зорилго 6 зорилт 47 ажил, арга хэмжээтэйгээр баталж 2025 оны эхний хагас жилд төлөвлөсөн 47 ажил, арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж хувьтай 98.93 хувьтай үргэлжилж байна. Төлөвлөгөөт ажлаас 100% - 42, 90% - 5, тус тус хэрэгжүүлж ажиллахдаа улсын төсвөөс 435,587,822.0(дөрвөн зуун гучин таван сая таван зуун наян долоон мянга найман зуун хорин хоёр) төгрөг, нийслэлийн төсвөөс 2,234,523,000.0 (хоёр тэрбум хоёр зуун гучин дөрвөн сая таван зуун хорин гурван мянган) төгрөгийг зарцуулсан байна.

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.САРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ХҮСЛЭНБАЯР

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2025 оны ..12... дугаар сарын 03..-ны өдрийн
..02/254.... дугаар албан бичгийн хоёрдугаар
хавсралт

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 03 Улаанбаатар хот

## НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

### НЭГ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО:

Нийслэлийн биеийн тамир, спортын газрын 2025 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн тайланд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

### ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ:

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 03 дугаар хавсралт "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ыг удирдлага болгов.

Нийслэлийн биеийн тамир, спортын газрын 2025 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн тайланд 2 зорилго, 6 зорилтын 47 арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээг гүйцэтгэв. Үүнд:

(Хүснэгт-1)

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Зарцуул-сан Төсөв (мян.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2024 | Зорилтот түвшин 2025 | Хүрсэн түвшин | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 1.<br>Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангана. СТ-1.1-1.4, НСТ-2.2, 2.3 | | | | | | | |
| Стратеги төлөвлөгөөний зорилт 1.<br>Иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3, НЗДҮАХ-2.1.7, 2.1.8. | | | | | | | |
| 1.1. | Нийслэл, дүүргийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, биеийн тамир, спортын клуб, өсвөрийн шигшээ багийн багш, дасгалжуулагч, арга зүйч, албан хаагчдад зориулсан сургалтыг зохион байгуулна. | Улсын төсөв 10,040.0 | Сургал-тын тоо | 6 | 8 | 8 | 100% |
| 1.2. | Ахмад насны иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд хамруулж дэмжлэг үзүүлнэ. | - | Иргэдийн тоо | 7042 | 7394 | 9117 | 100% |
| 1.3. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийслэл, дүүргийн | Нийслэл, Улсын | Оролцогч дын тоо | 2400 | 2520 | 2611 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээнд биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулж дэмжлэг үзүүлнэ. | төсөв 6,660.0 | | | | | |
| Стратеги төлөвлөгөөний зорилт 2.<br>Биеийн тамир, спортын байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх, хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох. НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3, НЗДҮАХ-2.1.7. | | | | | | | |
| 2.1. | Төрийн болон аж ахуй нэгж байгууллагын биеийн тамир, спортын клубын тоог нэмэгдүүлж үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | - | Клубын тоо | 815 | 820 | 820 | 100% |
| 2.2. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг авах ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж нэгдсэн мэдээллийн санд оруулна. | Нийслэл төсөв | Иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт | 74% (А, В, С үнэл-гээ авсан байна) | 75% (А, В, С үнэлгээ авсан байна) | 77% нь А,В,С үнэлгээ | 100% |
| Стратеги төлөвлөгөөний зорилт 3.<br>Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх НХТЖҮЧ-3.5.4, НЗДҮАХ-2.1.8, НХТ-161, 162. | | | | | | | |
| 3.1. | Оюутны шигшээ багийг спортын 8 төрлөөр байгуулах журмыг боловсруулж шаардагдах төсвийг 2026 оны төсөвт тусгуулна. /Биеийн тамир, спортын тухай хуулийн 23.6/ | - | Хэрэг-жил-тийн хувь | 0 | 100 | 100 | 100% |
| 3.2. | "Даншиг наадам-Хүрээ цам" наадмын үндэсний бөхийн барилдаан, үндэсний сур харвааг зохион байгуулна. | Нийслэлийн төсөв | Оролцогчдын тоо | 436 | 436 | 1256 | 100% |
| 3.3. | Гадаад, дотоодын биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцуулах, харилцан туршлага судлах ажлыг зохион байгуулна. | Улсын төсөв 8,400.0 | Арга хэмжээний тоо | 10 | 12 | 12 | 100% |
| Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2.<br>2.1.Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж болон спортын барилга байгууламжийн хүртээмжийг тус тус нэмэгдүүлнэ.<br>НХТЖҮЧ-3.5, НЗДҮАХ-2.1,7. НХТ-153, 154, 155 | | | | | | | |
| Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт: 1.<br>Нийслэлийн иргэдийг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлж, бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын түвшний суурь үзүүлэлтийг 5 хувиар өсгөнө. НХТЖҮЧ-3.5.1, 3.5.3, НЗДҮАХ-2.1.7, НХТ-153, 154, 155, 156 | | | | | | | |
| 1.1. | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Хэрэг-жил-тийн хувь | 99 | 25 | 100 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2. | Биеийн тамир, спортын хуулийн дагуу дүүргийн хороодод орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулахад холбогдох баримт бичгийг боловсруулж 2026 оны төсөвт тусгуулна. | - | Хэрэг-жилтийн хувь | - | 100 | 100 | 100% |
| 1.3. | Нийтийг хамарсан биеийн тамирын томоохон (Улаанбаатар марафон, Иргэдийн спортын “Хангарди” наадам, Бүжгийн фестиваль, Нийтийн гимнастикийн фестиваль, “Улаанбаатар цом” усанд сэлэлтийн фестиваль, “Алхацгаая-гүйцгээе” хөдөлгөөн гэх мэт) арга хэмжээнүүдийг зохион байгуулна. | Нийслэлийн төсөв Улсын төсөв 34,460.0 | Иргэдийн тоо | 888,500 | 916,978 | 1,117,358 | 100% |
| 1.4. | Нийслэлийн өвлийн спортын 9 арга хэмжээ, 5 төрөл (Цанын бааз, мөсөн гулгуурын талбай, битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбай, өдөрлөг, секц дугуйлан)-ийн үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллана. | Нийслэлийн төсөв | Арга хэмжээ | 12 | 14 | 20 арга хэмжээ, 447,595 иргэд | 100% |
| | | | Хамрагдсан иргэдийн тоо | 425,000 | 446,335 | | |
| Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 2.<br>Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлж, нийслэлийн иргэдийн дунд зохион байгуулах уралдаан, тэмцээн наадмын төрлийг нэмж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэж суурь үзүүлэлтийг 5 хувиар ахиулна.<br>НХТЖҮЧ-3.5.4, 3.5.5, НЗДҮАХ-2.1.8., НХТ-160, 161, 162, 156. | | | | | | | |
| 2.1. | Багийн спортыг дэмжих чиглэлээр өсвөрийн хүүхэд багачуудын дунд “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейболын тэмцээн, “Мөрөөдлийн гоол” хөл бөмбөгийн фестивалийг зохион байгуулна. | Нийслэлийн төсөв | Оролцогчдын тоо | 158,746 | 166,683 | 166,694 | 100% |
| 2.2. | Спортын холбоодтой 2025 онд хамтран ажиллах гэрээ байгуулан Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг спортын 21 төрлөөр зохион байгуулна. | Улсын төсөв 61,440.0 | Тамирчдын тоо | 7,888 | 8,282 | 8,631 | 100% |
| 2.3. | Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг байнгын дасгал сургалт хийх нөхцөлийг хангаж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэнэ. | - | Тамирчдын тоо | 3,150 | 3,307 | 4001 | 100% |
| 2.4. | Бүх ард түмний спортын XVII наадам, Хүүхдийн спортын VIII наадмын анхан шатны | Нийслэл төсөв | Хэрэгжилтийн хувь | - | 100 | 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмцээнүүдийг зохион байгуулна. | | | | | | |
| Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 3.<br>Нийслэлийн иргэдийн 15 хувь нь оршин суух газраасаа 20 минут алхаж хүрэх зайд ногоон байгууламж бүхий спортын цогцолборыг бий болгох, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцлийг сайжруулж, спортын барилга, байгууламжийн хүртээмжийг 1000 хүнд 70 м2-д хүргэж нэмэгдүүлнэ. НХТЖҮЧ-3.5.2, НЗДҮАХ-2.1.9, НХТ-157, 158, 159 | | | | | | | |
| 3.1. | Сонгинохайрхан дүүргийн өвлийн спортын ордон, Баянзүрх, Багахангай дүүргийн спорт цогцолборын барилгын ажлыг үргэлжлүүлнэ. | Улсын төсөв 5,526,400.0 | Гүйцэт-гэлийн хувь | 55 | 70 | 84.4 | 100% |
| 3.2. | Баянхошуу дэд төвийн спортын цогцолборын барилгын ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж ашиглалтад оруулна. | Азийн хөгжлийн сан 3,000,000.0 Нийслэлийн төсөв | Гүйцэт-гэлийн хувь | 70 | 100 | 85 | 85% |
| 3.3. | Биеийн тамир, спортын талбайн бүтээн байгуулалт, тохижилтыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. | - | Талбайн тоо (өссөн дүнгээр) | 203 | 223 | 234 | 100% |
| 3.4. | Нийслэлд спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | - | Спортын барилга байгууламжийн хүртээмж (м2) | 65 | 66 | 65<br><br>2026 оны 1 сард статисти-кийн тоон үзүүлэл-тээр спортын барилга байгууламжийн хүртээмж (м2) нэмэгдэнэ. | 100% |
| Зорилт 4. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт | | | | | | | |
| 4.1. | Улс, нийслэл, байгууллагын дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бусад холбогдох баримт бичгүүдэд санал боловсруулан хүргүүлж ажиллана. | - | Баримт бичгийн тоо | 12 | 12 | 12 | 100% |
| 4.2. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тайлан, мэдээг нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлнэ. | - | Хугацаа хоцроо-сон тайлан мэдээ-ний тоо | Хугацаа хэтэрч явуул-сан тайлан мэдээ-ний тоо 0 | Хугацаа хэтэрч явуулсан тайлан мэдээний тоо 0 | Хугацаа хэтэрсэн тайлан байхгүй | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн төлөвлөгөөнд манай байгууллагад хариуцуулан тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | - | Тайлан-гийн тоо | 10 | 10 | 12 | 100% |
| 4.4. | Байгууллагын албан хаагчдын шилжилт хөдөлгөөний мэдээг төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын системд оруулна. | - | Шинэчилсэн мэдээл-лийн тоо | 14 | 15 | 16 | 100% |
| 4.5. | Биеийн тамир, спортын салбарын байгууллагуудын статистик судалгааны дүн мэдээг шинэчилж нэгтгэн цахим программд оруулна. | - | Мэдээ-ний тоо | 7 | 7 | 7 | 100% |
| 4.6. | Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг тайлагнах, ХАСХОМ гаргах албан хаагчдыг хуулийн хугацаанд мэдүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Хэрэг-жил-тийн хувь | 100 | 100 | 100 | 100% |
| 4.7. | Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог шинэчлэн батлаж ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллана. | - | Хэрэг-жилтийн хувь | 100 | 100 | 100 | 100% |
| 4.8. | Нийслэлийн 2025 оны төсөвт батлагдсан байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр, авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнана. | Нийслэлийн төсөв 8,838.7 | Хэрэг-жил-тийн хувь | 100 | 100 | 100 | 100% |
| 4.9. | Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна. | - | Хэрэг жил-тийн хувь | 100 | 100 | 100 | 100% |
| 4.10. | Өөрийн эрхлэх чиг үүргийн хүрээнд салбарын хууль тогтоомж болон бусад хууль, тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлнэ | - | Сана-лын тоо | 1 | 1 | 2 | 100% |
| 4.11. | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс | - | Ажлын тоо | 11 | 12 | 12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. | | | | | | |
| 4.12. | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Ажлын тоо | 11 | 11 | 11 | 100% |
| 4.13. | Биеийн тамир, спортын чиглэлээр шинээр боловсруулах, шинэчлэх шаардлагатай стандарт, нормд санал өгөх, сурталчилан хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | - | Ажлын тоо, хүр-тээмж | 4 ажил, 1230 хүн | 5 ажил, 1250 хүн | 5 сургалт 1310 хүн | 100% |
| Зорилт 5.<br>Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: | | | | | | | |
| 5.1. | Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмыг шаардлагын дагуу хангаж ажиллана. | - | Чиг үүргийн тоо | 6 | 8 | 8 | 100% |
| 5.2. | Байгууллагын хэмжээнд дотоод хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Ажлын тоо | 4 | 2 | 2 | 100% |
| 5.3. | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын байнгын үйл ажиллагаатай хороо, комисс, зөвлөлүүд тус бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана. | - | Хэрэгжил тийн хувь | 100 | 100 | 100 | 100% |
| 5.4. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих ажлыг зохион байгуулна. | - | Тарь-сан модны тоо | 10 | 20 | 20 | 100% |
| Зорилт 6.<br>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт: | | | | | | | |
| 6.1. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн программ /erp.ulaanbaatar.mn/-ын дэд системүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандаа үргэлжлүүлэн ашиглана. | - | Ашигла сан дэд систе-мийн тоо | 14 | 15 | 16 | 100% |
| 6.2. | Иргэдийг хүлээж авах хуваарь гарган, санал хүсэлтийг цаг тухайд нь шийдвэрлэж ажиллана. | - | Хэрэг-жил-тийн хувь | 100 | 100 | 100 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.3. | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгайлсан арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Шийдвэр-лэлтийн дундаж хугацаа | 4 хоног 20 цаг | 4 хоног | 2 хоног 12 цаг 49 минут | 100% |
| 6.4. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем дэх edoc.ulaanbaatar.mn системийн ашиглалтыг сайжруулан албан бичгийн шийдвэрлэлтийг хангаж ажиллана. | - | Шийдвэр-лэлтийн хувь | 98 | 99 | 99 | 100% |
| 6.5. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын чиг үүргийн хүрээний мэдээллийг олон нийтэд ил тод хүргэж ажиллана. | - | Мэдээл лийн тоо | 68 | 69 | 72 | 100% |
| 6.6. | Нийслэлийн тэргүүний биеийн тамир, спортын байгууллага, спортын холбоод, хамтрагч байгууллага, хамтлаг, мэргэжилтэн, багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйчдийн хэрэгжүүлсэн ажилд үнэлэлт дүгнэлт өгч, шалгаруулж урамшуулна. | Улсын төсөв | Болзлын дагуу шалгар-сан шилдгүүдийн тоо | 11 | 22 | Хугацаа болоогүй | 70% |
| 6.7. | Биеийн тамир, спортын үйлчилгээ, хүртээмжийн талаарх судалгааг судалгааны багтай хамтран зохион байгуулж, үр дүнг тодорхойлно. | Улсын төсөв | Хэрэг-жил-тийн хувь | 0 | 100 | 90 | 70% |
| 6.8. | Иргэдэд үзүүлэх биеийн тамир, спортын зарим үйлчилгээг цахимд шилжүүлэх чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулна. | - | Цахимд шилжүүлсэн үйлчил-гээний төрлийн тоо | 8 | 9 | 9 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.9. | Байгууллагын чиг үүрэгт хамаарах "Хотын хөгжлийн индекс"-ийн холбогдох үзүүлэлтийн тоон мэдээллийг цуглуулах, нэгтгэх, мэдээлэх тогтолцоог бий болгох, суурь үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Хэрэг-жилтийн хувь | 0 | 100 | 100 | 100% |
| 6.10 | Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, ажилтан албан хаагчдын албан хэрэг хөтлөлтийн ур чадвар, мэдлэгийг сайжруулах төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Хэрэг-жилтийн хувь | 100 | 100 | 100 | 100% |
| Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 2 зорилго 6 зорилт 47 ажил, арга хэмжээтэйгээр баталж 2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөсөн 47 арга хэмжээнд хяналт шинжилгээ хийлээ. Зорилт тус бүрээр авч үзвэл: | | | | | | | |

Зорилт тус бүрийн хэрэгжилтийн үр дүн:

(Хүснэгт-2)

| № | Зорилтын нэр | Арга хэмжээний тоо | Зорил-тын дундаж хувь |
|---|---|---|---|
| 1 | Стратеги төлөвлөгөөний зорилт 1.<br>Иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 3 | 100 |
| 2 | Стратеги төлөвлөгөөний зорилт 2.<br>Биеийн тамир, спортын байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх, хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох. | 2 | 100 |
| 3 | Стратеги төлөвлөгөөний зорилт 3.<br>Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх | 3 | 100 |
| 4 | Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 1.<br>Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж болон спортын барилга байгууламжийн хүртээмжийг тус тус нэмэгдүүлнэ. | 4 | 100 |
| 5 | Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 2.<br>Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлж, нийслэлийн иргэдийн дунд зохион байгуулах уралдаан, тэмцээн наадмын төрлийг нэмж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэж суурь үзүүлэлтийг 5 хувиар ахиулна. | 4 | 100 |
| 6 | Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 3.<br>Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх | 4 | 93,7 |
| 7 | Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 4.<br>Нийслэлийн иргэдийг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлж, бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын түвшний суурь үзүүлэлтийг 5 хувиар өсгөнө. | 13 | 100 |
| 8 | Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 5.<br>Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх | 4 | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 6.<br>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах | 10 | 94 |
| Зорилтын дундаж | | 47 | 98,6% |

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу хяналт-шинжилгээ хийхэд төлөвлөгөөний хэрэгжилт 98,6 хувьтай буюу “бүрэн хангалттай” арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ 2025 оны жилийн эцсийн байдлаар хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан гэж дүгнэж үзлээ.

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.САРАНЦЭЦЭГ

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ОЮУНТУЯА

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2025 оны ..12.... дугаар сарын 05..-ний өдрийн
02/254........ дүгээр албан бичгийн гуравдугаар
хавсралт

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 дугаар сарын 03 Улаанбаатар хот

2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАНГ
ХЭЛЭЛЦЭХ ТУХАЙ

Даргын дэргэдэх Удирдлагын зөвлөлийн ээлжит хурал 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 13:30 цагаас Нийслэлийн нутгийн захиргааны “Б” байрны 1116 тоот өрөөнд болж Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга М.Цогзолмаа удирдан явуулав.

Хуралд Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга М.Цогзолмаа, Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Мөнх-Эрдэнэ, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Бямбасайхан, Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Б.Оюунтуяа, хурлын нарийн бичгээр Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн Б.Хүслэнбаяр, Хэвлэл мэдээлэл, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Н.Өлзийжаргал нар оролцлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хэлэлцэх.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн Б.Хүслэнбаяр танилцуулав.

СОНССОН НЬ:

М.Цогзолмаа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан ажлын тайланг хэлэлцэхээр цугларсан байна. Тайланг хэлтсийн ахлах нар хянасан уу, шууд эндээ хянахаар байна уу?

Б.Хүслэнбаяр: Хэлтсүүдээс нэгтгэхэд ахлахуудын баталсан тайланг авч нэгтгэсэн.

М.Цогзолмаа: За тайлангуудыг нэг бүрчлэн хоёр хэлтсийн ахлахад хэвлээд дор бүрнээ уншаад дэлгэцэд гаргаад яриад яриад явъя.(хэвлэж тараав)

Б.Хүслэнбаяр: Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд туссан арга хэмжээ, ажил үйлчилгээг хэрэгжүүлэх зорилгоор 6 зорилтыг хэрэгжүүлэх 47 ажил төлөвлөж жилийн эцсийн байдлаар 6 зорилт, 47 арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж 98%-тай тайлагналаа.

М.Цогзолмаа: Хэрэгжилтийг хараад санал, хүсэлтээ илэрхийлээд явъя.

Э.Мөнх-Эрдэнэ: Тайлан мэдээг нэгтгэхдээ найруулга дээрээ сайн анхаараарай.

Б.Хүслэнбаяр: За.

М.Цогзолмаа: Барилга байгууламжтай холбоотой ажлуудаас тайлан мэдээгээ яг нарийн авч байгаа юу?

Г.Бямбасайхан: Авч байгаа холбогдох хүмүүсээс нотлох баримттай нь авч байгаа.

М.Цогзолмаа: Сайн байна. Хэрэгжилтийн хувьд өөрчлөлт оруулах санал байна уу?

Бүгд: Байхгүй.

М.Цогзолмаа: Тэгвэл Б.Оюунтуяа хяналт-шинжилгээ үнэлгээний талаар хэлэх зүйл байна уу?

Б.Оюунтуяа: Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу хяналт-шинжилгээ хийхэд төлөвлөгөөний хэрэгжилт 98,6 хувьтай буюу "бүрэн хангалттай" арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ 2025 оны жилийн эцсийн байдлаар хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан гэж дүгнэж үзлээ.

М.Цогзолмаа: Тун сайн. Тэгвэл ингээд хурлаа өндөрлөх үү?

Бүгд: Тэгье дарга аа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1.Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 6 зорилт 47 арга хэмжээний гүйцэтгэлийн дунджийг 98 хувьтай гарсныг хэвээр үлдээж шийдвэрлэлээ.

2.Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг тодорхойлж бичсэн үг, өгүүлбэрийн утга найруулгыг дахиж нягтлахыг Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн Б.Хүслэнбаярт даалгав.

3.Тайланг Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамд нийцүүлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний газарт хүргүүлж ажиллахыг Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн Б.Хүслэнбаярт даалгав.

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.САРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ХҮСЛЭНБАЯР

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 02/254 дугээр албан бичгийн дөрөвдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

## 2025 ОНЫ НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 03 Улаанбаатар хот

| № | Нээлттэй мэдээлэл | Шалгуур үзүүлэлт | 2024 оны суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | | 7 | 8 |
| Нэг.Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын | | | | | | | |
| 1. | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн | Оруулсан биелэлтийн тоо | 2 | 1 | 1 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын эрхэм зорилгыг https://sport.ub.gov.mn/?page_id=2367, стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийг https://sport.ub.gov.mn/?page_id=4141, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг https://sport.ub.gov.mn/?page_id=290# холбоос (линк)-д хагас, бүтэн жилээр байршуулсан. | 100 |
| 2. | Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг | Оруулсан мэдээллийн тоо | 2 | 1 | 1 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг https://sport.ub.gov.mn/?page_id=124628, бүтэц, зохион байгуулалтыг http://sport.ub.gov.mn/?page_id=38, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг http://sport.ub.gov.mn/?page_id=40 холбоос (линк)-д хагас, бүтэн жилээр байршуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж | Оруулсан мэдээллийн тоо | 6 | 3 | 3 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас гаргасан эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, зөвлөмжийн талаарх мэдээллийг https://sport.ub.gov.mn/?page_id=3975, дотоод аудитын талаарх мэдээллийг http://sport.ub.gov.mn/?page_id=124776 холбоос (линк)-д 6 удаа байршуулсан. | 100 |
| 4. | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан | Оруулсан тайлангийн тоо | 2 | 1 | 1 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг https://sport.ub.gov.mn/?page_id=3975 холбоос (линк)-д хагас, бүтэн жилээр байршуулсан. | 100 |
| 5. | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан | Оруулсан тайлангийн тоо | 2 | 1 | 1 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас “Алсын хараа-2050”, “Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө”, “Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө” зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг 2025 оны хагас, бүтэн жилээр гаргасан тайлангуудыг https://sport.ub.gov.mn/?page_id=3975 холбоос (линк)-д хагас, бүтэн жилээр байршуулсан. | 100 |
| 6. | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт | Оруулсан актын тоо | 27 | 25 | 27 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас үйл ажиллагаандаа мөрдөж байгаа Монгол Улсын хуулиудыг https://sport.ub.gov.mn/?page_id=126, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг болон захирамжийг https://sport.ub.gov.mn/?page_id=6008, Монгол Улсын Засгийн газрын тогтоолыг https://sport.ub.gov.mn/?page_id=3961, Монгол Улсын Засгийн газрын Албан даалгаварыг https://sport.ub.gov.mn/?page_id=124807, Монгол Улсын Засгийн газрын Хуралдааны тэмдэглэлийг https://sport.ub.gov.mn/?page_id=124803 холбоосууд (линк)-д тус тус байршуулсан. | 100 |
| 7. | Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн | Оруулсан мэдээллийн | 2 | 1 | 1 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын ажилтан албан хаагч тус бүрийн албан тушаалын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг | тоо | | | | тодорхойлолтыг http://sport.ub.gov.mn/?page_id=3975, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг http://sport.ub.gov.mn/?page_id=40 холбоосууд (линк)-д 2 удаа байршуулсан. | |
| 8. | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ | Оруулсан тайлангийн тоо | 4 | 2 | 2 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2025 оны 1, 2, 3 4 дүгээр улирлын тайлан, мэдээг https://sport.ub.gov.mn/?page_id=6833 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 9. | Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл | Оруулсан тайлангийн тоо | 1 | 1 | - | Биеийн тамир, спортын төрийн байгууллагын үйл ажиллагааны 2024 оны мэдээг Үндэсний Статистикийн газрын 3-БТС-1, А-БТС-6, А-БТС-7 маягтын дагуу бэлтгэн https://cpanel.sport.gov.mn/ программд хугацаанд нь 7 төрлийн мэдээ оруулсан бол цаасан хэлбэрээр 2025 оны 01 дүгээр сарын 25-ны хүргүүлсэн мэдээг Засгийн газрын Тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын Улсын хороонд хүргүүлж, http://sport.ub.gov.mn/?page_id=124663, https://sport.ub.gov.mn/?page_id=6833 холбоосууд (линк)-д байршуулсан. | 100 |
| 10. | Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр | Оруулсан тайлангийн тоо | 2 | 1 | 1 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 онд зохион байгуулах биеийн тамир, спортын уралдаан тэмцээн болон олон нийтийн арга хэмжээний календарчилсан төлөвлөгөө, хөтөлбөрийг http://sport.ub.gov.mn/?page_id=7032 холбоост байршуулсан. | 100 |
| Хоёр.Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | | | | | |
| 1. | Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл | Оруулсан мэдээллийн тоо | 2 | 4 | 2 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт шаардлагатай байгаа ажлын байрны 4-н сул орон тооны талаарх мэдээллийг 2025 онд нийт 6 удаа гаргаж http://sport.ub.gov.mn/?page_id=8433 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 2. | Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам | Оруулсан журмын тоо | 1 | 1 | - | Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | журам"-ыг https://sport.ub.gov.mn/?page_id=122 холбоос (линк)-т байршуулсан. | |
| 3. | Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм | Оруулсан дүрмийн тоо | 1 | 1 | 1 | "Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын албан хаагчдын ёс зүйн журам"-ыг байгууллагын даргын 2025 оны А/13, А/28 дугаар тушаалуудаар 2 удаа шинэчлэн баталсан http://sport.ub.gov.mn/?page_id=130 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 4. | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам | Оруулсан журмын тоо | 1 | 1 | - | Байгууллагын даргын 2025 оны А/23 дугаар тушаалаар батлагдсан "Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025-2028 оны хөтөлбөр"-ийг http://sport.ub.gov.mn/?page_id=124815 холбоос (линк)-т, "Хүний нөөцийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг http://sport.ub.gov.mn/?page_id=124823 холбоос (линк)-т, "Хүний нөөцийн стратеги, бодлого, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам"-ыг https://sport.ub.gov.mn/?page_id=122 холбоос (линк)-т тус тус байршуулсан. | 100 |
| 5. | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ | Оруулсан арга хэмжээний тоо | 2 | 1 | 1 | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хүрээнд хийсэн байгууллагын хүний нөөцийн 2025 оны хагас жилийн дэлгэрэнгүй тайланг https://sport.ub.gov.mn/?page_id=122 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 6. | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам | Оруулсан журмын тоо | 1 | 1 | - | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолыг тус тус https://sport.ub.gov.mn/?page_id=124795 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| Гурав.Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны | | | | | | | |
| 1. | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | - | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг http://sport.ub.gov.mn/?page_id=4000 холбоос (линк)- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | т, тухайн жилийн төсвийг http://sport.ub.gov.mn/?page_id=3998 холбоос (линк)-т, дараа оны төсвийн төслийг http://sport.ub.gov.mn/?page_id=4002 холбоос (линк)-т тус тус байршуулсан. | |
| 2. | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан | Оруулсан тайлангийн тоо | 2 | 1 | 1 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг http://sport.ub.gov.mn/?page_id=124846 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 3. | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт | Оруулсан дүгнэлтийн тоо | 1 | 1 | - | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг http://sport.ub.gov.mn/?page_id=4006 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 4. | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | - | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 онд зохион байгуулсан “Улаанбаатар марафон-2025” олон улсын гүйлт зохион байгуулах тухай” удирдамжийг http://sport.ub.gov.mn/?page_id=4010 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 5. | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | Оруулсан мэдээллийн тоо | 12 | 6 | 6 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны батлагдсан төсөв жилээр: 628,062,000 төгрөг; батлагдсан төсөв тайлант үе (өссөн дүнгээр): 411,238,700 төгрөг; батлагдсан төсвийн гүйцэтгэл (өссөн дүнгээр): 389,698,640.25 төгрөг; хэмнэлт, хэтрэлт (өссөн дүнгээр): 21,540,060.40 төгрөг, түүний шалтгааны тайлбарын хамт 2025 онд сар бүр хуулийн хугацаанд нь https://shilendans.gov.mn/organization/47893 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 6. | Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг | Оруулсан мэдээллийн тоо | 12 | 6 | 6 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг бүхий мэдээллийг хуулийн хугацаанд нь 2025 оны 01-12 дугаар саруудад https://shilendans.gov.mn/organization/47893 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 7. | Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий | Оруулсан мэдээллийн тоо | 12 | 6 | 6 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлогын нийт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт | | | | | 2,613,211,620.00 төгрөгийн 102 гүйлгээ, зарлагын нийт 1,632,105,440.00 төгрөгийн 33 мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт хуулийн хугацаанд нь 2025 онд сар бүр https://shilendans.gov.mn/organization/47893 холбоос (линк)-т байршуулсан. | |
| 8. | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | Оруулсан мэдээллийн тоо | 12 | 6 | 6 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, концесс байхгүй болно. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн байгууллагын даргын 20-н “А” тушаал, 6-н “Б” тушаалуудыг хуулийн хугацаанд нь 2025 онд сар сард нь https://shilendans.gov.mn/organization/47893 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 9. | Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | - | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэлийг http://sport.ub.gov.mn/?page_id=124858 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 10. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | - | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа хийгддэггүй учраас "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан" зэрэгт холбогдолтой мэдээлэл байхгүй талаарх мэдээллийг http://sport.ub.gov.mn/?page_id=4387 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 11. | Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | - | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас худалдан авах ажиллагаа, тендер зарлагддаггүй тул худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлан, дүгнэлт | | | | | болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт байхгүй талаарх мэдээллийг http://sport.ub.gov.mn/?page_id=4387 холбоос (линк)-т байршуулсан. | |
| 12. | Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | - | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас худалдан авах ажиллагаа, тендер зарлагддаггүй тул худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт байхгүй талаарх мэдээллийг http://sport.ub.gov.mn/?page_id=4387 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 13. | Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | - | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 онд биеийн тамир, спортын чиглэлээр төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр авч хэрэгжүүлээгүй талаарх мэдээллийг http://sport.ub.gov.mn/?page_id=4387 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 14. | Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | - | 2025 онд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын захиалгаар Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төвөөс хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил мэдээллийг http://sport.ub.gov.mn/?page_id=4387 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн | | | | | | | |
| 1. | Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | - | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 онд зохион байгуулах спорт, нийтийн биеийн тамирын уралдаан тэмцээн, арга хэмжээний нэгдсэн календарчилсан төлөвлөгөө; төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл бүхий "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлт зохион байгуулах тухай" удирдамж зэргийг http://sport.ub.gov.mn/?page_id=124070 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 2. | Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | 1 | Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой аливаа үйлчилгээ явуулдаггүй талаарх мэдээллийг http://sport.ub.gov.mn/?page_id=124070 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. | | | | | | |
| Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | | | | | |
| 1. | Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | - | Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг http://sport.ub.gov.mn/?page_id=123890 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 2. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан | Оруулсан тайлангийн тоо | 2 | 1 | 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдал, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө, 2025 оны хагас, бүтэн жилийн тайланг http://sport.ub.gov.mn/?page_id=4388 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 3. | Албан тушаалтны Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | - | Албан тушаалтны Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл зэргийг http://sport.ub.gov.mn/?page_id=4388 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 4. | Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт | Оруулсан дүгнэлтийн тоо | 1 | 1 | - | Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт зэргийг http://sport.ub.gov.mn/?page_id=4388 холбоос (линк)-т байршуулсан. | 100 |
| 5. | Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны | Оруулсан мэдээллийн | 1 | 1 | - | Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэл | тоо | | | | төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийн талаарх мэдээллийг http://sport.ub.gov.mn/?page_id=4388 холбоос (линк)-т байршуулсан. | |
| 6. | Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл | Оруулсан мэдээллийн тоо | 1 | 1 | - | Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэлийг https://sport.ub.gov.mn/?page_id=3975 холбоос (линк)-д байршуулсан. | 100 |

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.САРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА М.ЦОГЗОЛМАА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.ӨЛЗИЙЖАРГАЛ